



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Ерөнхий дүгнэлт: Төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г батлаагүй, зарим хөрөнгө оруулалтын ажлыг чанартай гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд нь нөлөөлж байна.



АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатар хот
2025 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.11, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2025/06-11-ШТА-ГА) тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дарга (Б.Мөнхбат)-д зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2025 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4.Тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	3-3
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	4-4
	Хавсралтын жагсаалт	4-4
Дэд дарга	Дүрслэлийн жагсаалт	4-4
	Графикийн жагсаалт	4-4
	Зургийн жагсаалт	4-4
Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5-5
Аудитын менежер:	Ерөнхий мэдээлэл	6-6
Ахлах аудитор:	А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх?	7-13
Аудитор:	А.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн, холбогдох зардлын тооцоолол хийсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?	9-9
	А.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, эдийн засаг нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?	10-13
	Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан уу?	14-22
	Б.1. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, хууль журмын хүрээнд шалгаруулсан уу?	14-16
	Б.2. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хяналт хэрэгжүүлж, хүлээн авсан уу?	17-22
	В. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан уу?	23-27
	В.1. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?	23-23
	В.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?	24-26
	В.3 Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, өмчийн бүртгэлд тусгасан уу?	26-27
	Аудитын дүгнэлт	28-28
	Аудитын зөвлөмж	29-29
	Холбогдох байгууллагын санал	30-30
	Саналд өгсөн тайлбар	31-31
	Хавсралт	32-43
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787		
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.		

ТОВЧИЛСОН ҮГ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ГУББГ ОНӨААТҮГ	Геодези, усны барилга байгууламжийн газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг Дарга
ЗХУТ	Замын хөдөлгөөний удирдлагын төв
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
кВт	Кило ватт
МВт	Мега ватт
МВтц	Мега ватт цаг
МУ	Монгол Улс
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн засаг дарга
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ННТБГ	Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар
НОСБГ	Нийслэлийн орон сууцны бодлогын газар
НОСК	Нийслэлийн орон сууцны корпорац
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НТХО	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НЦХМТГ	Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УБ лифт	Улаанбаатар лифт ОНӨТҮГ
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
УБЗЗАГ ОНӨААТҮГ	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар
УБХАЗТБНТХНэгж ОНӨТҮГ	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
УБХХХХБШ төсөл	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төслийн нэгж
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБХГ	Хот байгуулалт хөгжлийн газар
ХТГ	Хот тохижилтын газар
ХТСИ	Хот төлөвлөлт, судалгааны институт
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний өөрчлөлт	7-7
Хүснэгт 2	Шинээр төлөвлөсөн ТАХ-ний ангилал	7-7
Хүснэгт 3	Нийслэлийн 2024 оны батлагдсан төсвийн өөрчлөлтүүд	8-8
Хүснэгт 4	Зардлын тооцоолол хийгдээгүй ТАХ	9-9
Хүснэгт 5	Нийслэлийн 2024 оны хөрөнгө оруулалтын ТАХ-ний ангилал	10-10
Хүснэгт 6	Зураг төсөвгүй ТАХ	12-12
Хүснэгт 7	Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй ТАХ	12-12
Хүснэгт 8	Эрх шилжүүлсэн ТАХ	14-14
Хүснэгт 9	Он дамжсан, тайлант онд хэрэгжсэн, хэрэгжээгүй ТАХ	17-17
Хүснэгт 10	Нийслэлийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар олгосон санхүүжилт	24-24
Хүснэгт 11	Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй	24-24
Хүснэгт 12	Гэрээний алданги тооцоогүй төсөл арга хэмжээ	25-25
Хүснэгт 13	Хөрөнгө бүртгэлд тусгасан ТАХ	26-27

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Холбогдох зардлын тооцоог хавсаргаагүй тусгасан төсөл арга хэмжээ	32-33
Хавсралт 2	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд, богино хугацааны баримт бичигт нийцээгүй баталсан ТАХ-ний жагсаалт	33-33
	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны (НХЖТ-2024) баримт бичигт нийцээгүй баталсан ТАХ-ний жагсаалт	33-34
Хавсралт 3	Ерөнхий нэрээр тусган баталсан төсөл арга хэмжээ	34-35
Хавсралт 4	Өмчлөлд шилжих боломжгүй ТАХ-ний жагсаалт	35-36
Хавсралт 5	Нийслэлийн 2024 оны Хөрөнгө оруулалтын саналгүй ТАХ-ны жагсаалт	36-36
Хавсралт 6	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ	36-38
Хавсралт 7	ТАХ-г төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн	39-39
Хавсралт 8	Худалдан авах ажиллагаа зохион байгуулахад илэрсэн зөрчил	40-40
Хавсралт 9	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл, арга хэмжээг тэнцүү хуваарилсан хэмжээнээс багаар тооцож баталсан	41-43
Хавсралт 10	Тодотголоор санхүүжих дүнг бууруулсан төсөл арга хэмжээ	43-43

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	Нийслэлд үнэт цаас гаргах тухай шийдвэрүүд	8-8
Дүрслэл 2	ТАХ-ний ерөнхий нэрээр баталсан байдал	11-11
Дүрслэл 3	Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө	14-14
Дүрслэл 4	Төсөвт өртөг, санхүүжих дүнг тойм дүнгээр төсөвт тусгасан ТАХ	23-23

Графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	НЗД-аас ХАА-ны эрхийг шилжүүлсэн байдал	15-15

Зургийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Зураг 1	Хэрэгжиж дууссан ТАХ	18-18
Зураг 2	Дулаан, цахилгааны асуудлаас шалтгаалж, хөрөнгө оруулалтын ажил удааширсан ТАХ	19-19
Зураг 3	Цэвэр усны зөвшөөрөл олгогдоогүйгээс ажил удааширсан	19-19
Зураг 4	Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй ТАХ	20-20
Зураг 5	БГД, 18 дугаар хороо Түшиц хана засварлах ажил	21-21
Зураг 6	ХУД, 23 хороо цэцэрлэгийн барилга худалдан авах ТАХ	22-22

	<p>Аудитын зорилт, хамрах хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p>
<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалаар баталсан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хүрээнд хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Нийслэлийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ○ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх; ○ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан эсэх; ○ Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх.
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад НЗДТГ, УБЗАА, НХААГ, НЗХГ, НБГ, НОСБГ, НОСК, НГЗБА, ННТБГ, НӨХГ, НХОГ ОНӨААТҮГ, УБХАЗТБНТХН, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, гэрээний хэрэгжилт, санхүүжилт зэргийг хамруулсан.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн</p>	<p>Аудитыг Гүйцэтгэл, нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Дайриймаа, аудитор З.Баярбилэгт, Ц.Ариунболд, Ц.Алтантуяа нар гүйцэтгэв.</p>

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 122 дугаар тогтоолоор Нийслэлийн 2024 оны төсвийг баталсан.


Дээрх тогтоолын 2, 3, 5, дугаар хавсралтуудаар 2024 онд шинээр хэрэгжих болон өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 2,370,122.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 334 багц ТАХ-г 1,152,467.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- Шинээр хэрэгжих 708,904.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 багц ТАХ,
- Шилжин хэрэгжих 885,045.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 96 багц ТАХ,
- Өмнөх онуудаас дамжин хэрэгжиж буй 776,173.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 166 ТАХ.

Нийслэлийн 2024 оны төсөвт нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орж /2024.02.28, 2024.06.18, 2024.09.24, 2024.12.25/ батлагдсан ТАХ-г 377 багц, төсөвт өртгийг 1,916,478.3 сая төгрөг, тайлант онд санхүүжих дүнг 764,011.0 сая төгрөг болгон өөрчилж, тодотгон баталсан байна.

Төсвийн тодотголоор 5,443,292.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ нэмэгдэж, нийт 7,813,415.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 377 багц ТАХ болсон байна.

Төсөл арга хэмжээнд эзлэх хувь



Шинээр хэрэгжих 113 багц ТАХ-г нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 535 ТАХ болгон хувааж захирамж гаргасан, өмнөх оноос болон шинээр нийт 924 ТАХ-г хэрэгжиж байна.

Шинээр хэрэгжих болон өмнөх онд ХАА зохион байгуулж дуусаагүй байсан нийт 857 ТАХ-ээс 667 ТАХ-нд зохион байгуулж 78.0 хувьд нь гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин хэрэгжсэн болон шинээр эхэлсэн нийт 2,097,432.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 788 ТАХ-д НХОГ ОНӨААТҮГ, НЗХГ, НЗДТГ, УБЗАА, ХБХГ, НГЗБА, НЭМГ, ННТБГ, УБ-Лифт ОНӨТҮГ зэрэг 20 байгууллагаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ.

Үүнээс 2024 онд 392,881.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 199 ТАХ буюу 25.3 хувь нь хэрэгжиж дууссан, 1,704,550.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 589 ТАХ буюу 74.7 хувь нь хэрэгжилт дутуу он дамжин хэрэгжиж байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжих болон шинээр хэрэгжих 7,813,415.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 377 багц ТАХ /задарснаар 924 ТАХ/-нд 2024 онд 1,916,478.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоос, 1,124,073.2 сая төгрөг буюу 58.6 хувийг олгожээ.

А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ?

НИТХ-ын 2023 оны “Нийслэлийн 2024 оны төсөв батлах тухай” 122 дугаар тогтоолоор 2024 онд шинээр 708,904.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 багц ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.

Хүснэгт 1. Шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний өөрчлөлт

(сая.төг)

Батлагдсан	Тогтоол				
	2023.12.05-ны өдрийн 122 дугаар	2024.02.28-ны өдрийн 25 дугаар	2024.06.18-ны өдрийн 88 дугаар	2024.09.24-ны өдрийн 105 дугаар	2024.12.25-ны өдрийн 24/32 дугаар
Тоо	72	90	97	113	113
Төсөвт өртөг	708,904.0	5,718,471.3	5,737,010.7	5,969,809.6	5,969,809.6
Санхүүжих дүн	646,026.6	1,205,211.0	1,203,705.9	1,360,060.8	1,360,060.8

Нийслэлийн 2024 оны төсөвт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орж анх төлөвлөснөөс ТАХ-г 41 багцаар, төсөвт өртгийг 5,260,905.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 5,969,809.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 113 багц ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталжээ. ТАХ-ний анхны төсөвт өртөг нь 5,260,905.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь автозамын түгжрэл бууруулах чиглэлийн томоохон арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэхтэй холбоотой байна. Тухайлбал:

- Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барих төслийн бүтээн байгуулалтын ажил, 2024-2028 онд хэрэгжих ТАХ, төсөвт өртөг 4,548,375.0 сая төгрөг;
- Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барих төслийн зөвлөх үйлчилгээ 2024-2028 онд хэрэгжих ТАХ, төсөвт өртөг 180,000.0 сая төгрөг;
- Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн систем, төсөвт өртөг 22,799.1 сая төгрөг.

Хүснэгт 2. Шинээр төлөвлөсөн ТАХ-ний ангилал

(сая.төг)

№	Ангилал	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Барилга байгууламж	57	5,529,507.5	1,078,638.1
2	Их засвар	15	36,674.9	36,268.5
3	Тоног төхөөрөмж	15	93,487.7	81,975.1
4	Зураг төсөв	3	197,164.7	51,707.5
5	Авто зам	23	112,974.7	111,471.6
НИЙТ		113	5,969,809.5	1,360,060.8

Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний 50.4 хувийг барилга байгууламж, 13.3 хувийг их засвар, 13.3 хувийг тоног төхөөрөмж, 2.7 хувийг зураг төсөв, 20.4 хувийг авто замын ангилалд хамаарах ажлуудыг төлөвлөжээ.

Үнэт цаас, бондын эх үүсвэрээс санхүүжигдэх ТАХ

Өрийн удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1¹-д “...Нийслэл нь тодорхой төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтээр, гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт

¹ 28¹.1.Аймаг, нийслэл нь тодорхой төсөл, арга хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно. Нийслэл нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно.

бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаагаар гаргаж болно” гэж заасан.

Мөн хуулийн 28.4²-т нийслэлийн ЗД нь үнэт цаас гаргах тухай саналаа ИТХ-д танилцуулах бөгөөд дэмжсэн шийдвэр гарсан тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулна гэж заажээ. Үүний дагуу нийслэлээс үнэт цаасыг дараах байдлаар дотоодын зах зээлд гаргасан байна.

Дүрслэл 1. Нийслэлд үнэт цаас гаргах тухай шийдвэрүүд

НИТХ-ын 2024.04.29-ны 48 дугаар тогтоол

Нийслэлд үнэт цаас дотоодын зах зээлд гаргаж арилжаалахыг дэмжсэн.

УИХ-ын 2024 оны 17, МУ-ын ЗГ-ын 2024 оны 201, 264, 265 дугаар тогтоолууд. МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичиг болон нийслэлийн хөгжүүлэх дунд хугацааны баримт бичигт нийцүүлэн тодорхой төсөл арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор 500.0 (таван зуу) хүрэлтх тэрбум төгрөгийн нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд 2024 онд багтаан арилжаалахыг НЗД бөгөөд УБ хотын захирагчид даалгасан.

НИТХ-ын 2024 оны 47, 48, 88, 89 дүгээр тогтоолууд.

"Нийслэлийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор тодорхой хэмжээний төсөл арга хэмжээг нийслэлийн үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант онд гадаад зах зээлд 500.0 сая ам.доллар, дотоодын зах зээлд 1.0 их наяд төгрөгийн урт хугацаат үнэт цаас гаргах зөвшөөрлийг авсан байна. Гүйцэтгэлээр урт хугацаат үнэт цаасаар дотоодын зах зээлээс 798.3 тэрбум төгрөг, гадаад зах зээлээс 1,712.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, данс бүртгэлд тусгасан байна.

Хүснэгт 3. Нийслэлийн 2024 оны батлагдсан төсвийн өөрчлөлтүүд

№	Огноо, дугаар	ТАХ хэрэгжих	Батлагдсан			Өсөлт / бууралт		
			тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	“Нийслэлийн 2024 оны төсөв батлах тухай” 2023.12.05-ны өдрийн 122 дугаар тогтоол	Шинэ	72	708,904.0	646,026.6	-	-	-
		Шилжих	96	885,045.2	332,947.5	-	-	-
		Он дамжих	166	776,173.4	173,493.2	-	-	-
		НИЙТ	334	2,370,122.6	1,152,467.3	-	-	-
2	“Нийслэлийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2024.02.28-ны өдрийн 25 дугаар тогтоол	Шинэ	90	5,718,471.3	1,205,211.0	18	5,009,567.3	559,184.4
		Шилжих	100	788,787.7	270,137.8	4	(96,257.5)	(62,809.7)
		Он дамжих	165	662,773.4	137,254.7	(1)	(113,400.0)	(36,238.5)
		НИЙТ	355	7,170,032.4	1,612,603.5	21	4,799,909.8	460,136.2
3	“Нийслэлийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2024.06.18-ны өдрийн 88 дугаар тогтоол	Шинэ	97	5,737,010.7	1,203,705.9	7	18,539.4	(1,505.1)
		Шилжих	100	808,261.0	275,248.2	-	19,473.3	5,110.4
		Он дамжих	160	659,542.4	132,524.6	(5)	(3,231.0)	(4,730.1)
		Шинэ/Үнэт цаас	7	2,348,809.4	2,338,200.0	7	2,348,809.4	2,338,200.0
НИЙТ	364	9,553,623.5	3,949,678.7	9	2,383,591.1	2,337,075.2		
4	“Нийслэлийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2024.09.24-ны өдрийн 105 дугаар тогтоол	Шинэ	113	5,969,809.6	1,360,060.8	16	232,798.9	156,354.9
		Шилжих	107	873,973.3	282,566.4	7	65,712.3	7,318.2
		Он дамжих	155	644,133.2	123,851.1	(5)	(15,409.2)	(8,673.5)
		Шинэ/Үнэт цаас	7	2,368,809.4	2,338,200.0	-	20,000.0	-
НИЙТ	382	9,856,725.5	4,104,678.3	18	303,102.0	154,999.6		
5	“Нийслэлийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2024.12.25-ны өдрийн 24/32 дугаар тогтоол	Шинэ	113	5,969,809.6	1,360,060.8	-	-	-
		Шилжих	107	873,973.3	282,566.4	-	-	-
		Он дамжих	155	644,133.2	123,851.1	-	-	-
		Шинэ/Үнэт цаас	2	325,498.9	150,000.0	(5)	(2,043,310.5)	(2,188,200.0)
НИЙТ	377	7,813,415.0	1,916,478.3	(5)	(2,043,310.5)	(2,188,200.0)		

² 28¹.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга үнэт цаас гаргах тухай саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах бөгөөд дэмжсэн шийдвэр гарсан тохиолдолд төсвийн жил эхлэхээс дөрвөөс доошгүй сарын өмнө санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлж, нийслэлд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний үр ашгийг тооцож төлөвлөсөн байна.

А.1. Холбогдох зардлын тооцоолол хийсэн, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2³, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянан, тайлагнах” журмын 2.2.4⁴-д шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд хууль, журамд заасан үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт, тооцооллыг гаргаж хавсаргахаар тусгасан.

Шинээр хэрэгжүүлэхээр баталсан 113 багц ТАХ-ээс барилга байгууламжийн ангилалд хамаарах 57 ТАХ-нд зардлын тооцоолол хийхээс 33 ТАХ буюу 57.8 хувьд нь бүрэн, 24 буюу 42.2 хувьд нь хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт байхгүй байна. **Хавсралт 1**

Хүснэгт 4. Зардлын тооцоолол хийгдээгүй ТАХ

(сая.төг)

Зардлын тооцоолол хийгдэх шаардлагатай			Үүнээс зардлын тооцоолол хийгдээгүй		
ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
57	5,529,507.5	1,078,638.1	24	150,975.7	94,618.6

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 5,969,809.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 113 багц ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд 5,882,020.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 ТАХ буюу 88.5 хувийг нийцүүлсэн, 87,789.1 сая төгрөгийн төсөвт 13 ТАХ буюу 11.5 хувь нь нийцээгүй байна.
- “Нийслэлийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 5,866,864.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 ТАХ буюу 89.4 хувийг нийцүүлсэн, 102,945.6 сая төгрөгийн төсөвт 12 ТАХ буюу 10.6 хувь нь нийцээгүй байна. **Хавсралт 2**

Дүгнэлт: Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний 89.0 хувийг хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигтэй нийцүүлж, барилга байгууламжийн ангилалд хамаарах ТАХ-ний 42.2 хувьд нь зардлын тооцоолол хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гаргаагүй байна.

³ 29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

⁴ 2.2.4.Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

А.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, эдийн засаг нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 2.3.2.1⁵-д орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнахаар заасан.

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байдлын авч үзэхэд дээрх журамд заасан шалгуур үзүүлэлт, маягт (хавсралт 1)-ын дагуу үнэлж эрэмбэлээгүй байна.

Гэвч Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4⁶, 4.5⁷, 5 дугаар зүйлийн 5.10⁸-д заасны дагуу ТАХ-г эрэмбэлэхдээ шилжих буюу хэрэгжүүлж буй ТАХ, өмнөх оноос хэрэгжсэн ТАХ, их засвар, шинээр хэрэгжүүлэх ТАХ гэсэн дарааллаар, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн төслүүд байх гэсэн үзүүлэлтийг харгалзан үзэж эрэмбэлсэн байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шилжин хэрэгжих 392,881.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 389 багц ТАХ, шинээр хэрэгжүүлэх 6,331,806.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 535 багц ТАХ, нийт 7,813,415.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 924 багц ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор ангилж, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ гэсэн дарааллаар эрэмбэлсэн байна. Тухайлбал:

Хүснэгт 5. Нийслэлийн 2024 оны хөрөнгө оруулалтын ТАХ-ний ангилал

(сая.төг)

Төсөв	Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
		Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Нийслэл	Барилга байгууламж	93	5,021,755.7	577,885.1	182	932,124.8	270,317.2	275	6,021,681.0	875,415.2
	Их засвар	53	60,341.6	53,122.5	69	21,516.3	3,221.3	122	149,658.4	83,556.7
	Тоног төхөөрөмж	48	217,829.0	188,031.0	19	72,632.9	-	67	358,262.3	215,243.9
	ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	25	207,821.7	62,364.4	58	41,762.9	3,423.0	83	317,385.1	93,000.3
	Захирамжлагдаагүй үлдэгдэл	-	428,173.3	421,402.4	-	-	-	-	428,173.3	421,402.4
	Дүн	219	5,935,921.3	1,302,805.4	328	1,068,037.0	276,961.6	547	7,275,160.1	1,688,618.4
Замын сан	Барилга байгууламж	2	2,313.0	2,313.0	12	124,217.4	2,870.2	14	126,530.4	5,183.2
	Их засвар	208	63,073.5	63,073.5	5	5,439.1	2,000.0	213	68,512.6	65,073.5
	Тоног төхөөрөмж	12	4,300.0	4,300.0	11	7,236.8	2,483.4	23	11,536.8	6,783.4
	ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	2	700.0	700.0	33	5,476.3	120.1	35	6,176.3	820.1
	Дүн	224	70,386.5	70,386.5	61	142,369.6	7,473.7	285	212,756.1	77,860.2
Үнэт цаас	Барилга байгууламж	92	325,498.9	150,000.1	-	-	-	92	325,498.9	150,000.1
НИЙТ		535	6,331,806.7	1,523,192.0	389	392,881,453	284,435.3	924	7,813,415.1	1,916,478.7

⁵ 2.3.2.1.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;

⁶ 4.4 Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална. Үүнд:..4.4.1 шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл

4.4.2 Их засварын төсөл, 4.4.3 Шинээр хэрэгжүүлэх төсөл

⁷ 4.5 Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

⁸ 5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй;

Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусган баталж, хэрэгжүүлэхээр заасныг тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

Ерөнхий нэрээр баталсан ТАХ:

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 5,969,809.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 113 багц ТАХ-нээс 5,171,986.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 85 ТАХ-г нэр байршил нэг бүрээр тусгасан байна.

Харин 797,820.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих дүнгээр 723,298.3 сая төгрөгийн 28 багц ТАХ-г Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4⁹-д заасныг зөрчиж ерөнхий нэршлээр баталсан байна. Эдгээр 28 багц ТАХ-г хэрэгжүүлэх шатанд НЗД-ын 2024 оны захирамжуудаар /450 ТАХ/ хувааж, ТАХ-ний төсөвт өртөг, хэрэгжүүлэх байршлыг тодорхойлсон байна. **Хавсралт 3** Тухайлбал:

- Ерөнхий боловсролын сургуулиудын гал тогооны их засварын ажил, төсөвт өртөг 3,608.0 сая төгрөг, НЗД-ын захирамжаар 21 ТАХ болсон;
- Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж төсөвт өртөг 14,792.9 сая төгрөг, НЗД-ын захирамжаар 18 ТАХ болсон;
- Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө боловсруулах, төсөвт өртөг 9,630.0 сая төгрөг, НЗД-ын захирамжаар 6 ТАХ болсон.

Дүрслэл 2. ТАХ-ний ерөнхий нэрээр баталсан байдал



Хөрөнгө оруулалтын бүс шинж чанартай ТАХ:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁰-т “Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэж заасан ч 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 17,841.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 багц ТАХ /захирамжаар хувааснаар 12/ нь өмчид бүртгэгдэхгүй, нийтийн орон орон сууцны дээвэр фасад засвар, цахилгаан шатны шинэчлэлтийн ажил байна.

Хавсралт 4 Тухайлбал:

- 61 дүгээр байрны фасадын засвар (Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо) төсөвт өртөг 1,000.0 сая төгрөг;
- 81/1 дүгээр байрны гадна фасад засвар (Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, их тойруу), төсөвт өртөг 1,091.0 сая төгрөг;
- Нийтийн зориулалттай цахилгаан шатыг шинэчлэлт (Баянзүрх дүүрэг), төсөвт өртөг 1,510.0 сая төгрөг.

¹⁰ 4.1.24. "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

Саналд үндэслээгүй төлөвлөж батлуулсан ТАХ:

- 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 5,969,809.6 сая төгрөг өртөгтэй 113 багц ТАХ-г олон нийтийн саналд үндэслэсэн эсэхийг шалгахад 81.3 хувь буюу 5,925,593.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 104 багц ТАХ нийцсэн, 44,216.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 багц буюу 7.9 хувь нь нийцээгүй байна. **Хавсралт 5**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1¹¹, 67 дугаар зүйлийн 67.3¹²-т заасны дагуу Нийслэлийн төсвийн төслийг боловсруулахдаа 2023 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр иргэдэд нээлттэй хэлэлцүүлэг, www.ulaanbaatar.mn цахим хуудсаар иргэдэд танилцуулж, санал авахад нийслэлийн 9 дүүргийн 230 гаруй иргэдээс давхардсан тоогоор нийт 637 санал ирүүлсэн байна.

Зураг төсөвгүй ТАХ:

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹³-д хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, магадлалаар баталгаажсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон ТАХ-г тусгана гэж заасан.

Барилга байгууламжийн ангилалд хамаарах 5,021,755.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 ТАХ-ээс 161,496.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 ТАХ нь зураг төсөвгүй байна. **Хавсралт 6**

Хүснэгт 6. Зураг төсөвгүй ТАХ

(сая.төг)

Зураг төсөв шаардагдах			Зураг төсөвтгүй		
ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
93	5,021,755.7	577,885.1	51	161,496.9	111,548.5

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4¹⁴-т төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байхаар заасан ч 2024 онд хэрэгжиж дуусах 26,840.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-ний гэрээг 2024 оны 10 дугаар сараас хойш байгуулсан байна. **Хавсралт 7**

Хүснэгт 7. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй ТАХ

(сая.төг)

№	Төсвийн эх үүсвэр	Эхлэх он	Дуусах он	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	Нийслэлийн төсөв	2024	2024	19	26,840.2
2	Үнэт цаас (бонд)	2024	2024	3	5,233.8
НИЙТ				22	32,074.0

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ээг баталснаас шалтгаалж ТАХ-ний хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нь нэмэгдэх, төсөвт ачаалал үүсэх сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тухайлбал:

“Улаанбаатар театр” ОНӨТҮГ-ын барилгын их засварын ажил, төсөвт өртөг 3,702.1 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2024-2024 он.

- НИТХ-ын 2024 оны “Төсвийн тодотгол батлах тухай” 105 дугаар тогтоолд “*магадлалын ерөнхий дүгнэлт, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт,*

¹¹ 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

¹² 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

¹³ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁴ 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй” дээрх ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан.

- НЗД-ын 2024 оны А/1156 дугаар захирамжаар НХААГ-т эрх шилжүүлж, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж тайлант онд хэрэгжээгүй;

ЧД-ийн 32-ын тойргийн үйлчилгээний барилга, тохижилт ногоон байгууламжийн ажил, төсөвт өртөг 16,547.8 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2024-2025 он.

- НЗД-ын 2024 оны А/234 дүгээр захирамжаар НХААГ-т эрх шилжсэн боловч захиалагчаас ажлын даалгаврыг 146 хонгийн дараа ирүүлж, гүйцэтгэгчтэй 2024 оны 09 дүгээр сард гэрээ байгуулснаар тохижилт, ногоон байгууламжийн ажлыг гүйцэтгэх, газар шорооны суурийн ажил хийх боломжийг алдсан,
- Цагаан эрэг 5 дугаар хэсгийн айл өрх (ХУД, 12 дугаар хороо) Багц-19, 2 дугаар гудамжны айл өрх (ХУД, 14 дүгээр хороо), гэрээний дүн 59.3 сая төгрөг, Гүйцэтгэгчээр “И Пи Эс групп” ХХК шалгарсан боловч дээрх ТАХ-г өөр эх үүсвэрээр санхүүжүүлснээр нийслэлийн төсвийн эх үүсвэрээр ажил хийгдээгүй байна.

Дүгнэлт: Шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ээс 263 ТАХ буюу 49.0 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй ч эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор ангилж, эрэмбэлсэн байна.

Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЖ, ХҮЛЭЭН АВСАН УУ?

Б.1. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, хууль журмын хүрээнд шалгаруулсан уу?

ТБОНӨХБАУХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.3¹⁵-т захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэхээр заасны дагуу 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дараах байдлаар хүргүүлжээ. Үүнд:

Дүрслэл 3. Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө



ХАА-ны төлөвлөгөөнд ТАХ-ний мөрдөх журам, арга, тендер зарлах огноо, хугацааг тодорхойлж хүргүүлсэн бөгөөд 2024 оны хөрөнгө оруулалтын ажлыг “Нээлттэй тендер шалгаруулах аргаар” зохион байгуулахаар тусгасан байна.

НЗД-ын 2024 оны 212 удаагийн захирамжаар 7,403,433.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 857 ТАХ-ний ХАА-г зохион байгуулах эрхийг харьяа 25 газарт шилжүүлсэн.

Үүнээс 2,255,276.2 сая төгрөгийн төсөвтэй 667 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8. Эрх шилжүүлсэн ТАХ

(сая.төг)

№	Эрх шилжсэн	НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ (НТ, ҮЦ, НЗС)			ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ		Тухайн ондоо амжаагүй ТАХ	
		Захирамж	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Гэрээний үнийн дүн	ТАХ	Төсөвт өртөг
1	НЗДТГ	11	20	168,443.73	15	131,385.96	5	37,057.77
2	УБ хотын ЗАА	5	9	27,006.92	8	24,501.48	1	2,505.45
3	НЗХГ	23	227	141,022.05	212	121,619.37	15	19,402.69
4	ННТБГ	1	1	250.00	1	223.79	-	26.21
5	НОСК	2	3	20,590.87	3	20,499.91	-	90.96
6	НХААГ	54	296	5,425,938.40	188	534,133.51	108	4,891,804.91
7	НХОГ	18	65	183,513.95	47	129,703.13	18	53,810.82
8	ХБХГ	1	1	719.33	1	719.33	-	-
9	НГЗБА	-	8	404,937.01	7	397,389.92	1	7,547.09
10	УБХГХХХОДХТНэгж	4	11	6,067.26	11	4,648.13	-	1,419.13
11	УБХХХБШ төсөл	2	2	378.00	2	378.00	-	-
12	ЗХУТ ОНӨААТҮГ	1	1	18.30	-	-	1	18.30
13	ГУББГ ОНӨААТҮГ	1	3	37,993.00	2	33,580.37	1	4,412.63
14	УБЗЗАГ ОНӨААТҮГ	2	9	3,654.20	4	3,654.20	5	-
15	УСУГ ОНӨААТҮГ	1	1	3,165.09	1	3,165.09	-	-
16	ХТГ ОНӨААТҮГ	1	1	4,000.00	1	4,000.00	-	-
17	ХТСИ ОНӨААТҮГ	2	3	3,304.60	3	3,304.60	-	-
18	БГД	6	10	55,763.45	9	36,987.73	1	18,775.72
19	БЗД	3	8	48,470.33	6	44,859.23	2	3,611.09
20	БНД	1	3	4,273.08	3	4,220.01	-	53.07
21	БХД	4	6	2,761.99	6	2,757.42	-	4.57
22	СХД	9	20	69,599.13	19	62,487.70	1	7,111.43
23	ХУД	2	2	500.00	2	484.30	-	15.70
24	ЧД	1	1	100.00	1	99.12	-	0.88
25	НД	1	1	865.20	1	864.72	-	0.48
26	Шилжин хэрэгжих	56	145	790,097.98	114	689,609.18	31	100,488.80
	НИЙТ	212	857	7,403,433.88	667	2,255,276.21	190	5,148,157.69

¹⁵ 44.3.Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ.

Харин 2024 онд 5,148,157.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, хэрэгжиж дуусаагүй 190 ТАХ байна. Үүнд:

- 4,873,277.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 ТАХ нь ТББ боловсруулах, үнэлгээ хийх шалтгаанаар тухайн онд бүрэн дуусаагүй он дамжин үргэлжилж байна;
- 51,503.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 ТАХ нь захиалагч байгууллагаас техникийн тодорхойлолт, зураг төсөв, ажлын даалгаваргүй шалтгаанаар худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй;
- 118,307.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 ТАХ нь НЗД-ийн захирамжаар хүчингүй болсон;
- 105,068.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 49 ТАХ нь шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүйгээс удаа дараа зарлагдан он дамжин гэрээ байгуулах эрх олгосон.

Нийслэл, дүүргийн худалдан авах ажиллагааны газар болон албанд нийт эрх шилжүүлсэн ТАХ-ний 41.0 хувь буюу 5,608.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 347 ТАХ-ний эрхийг шилжүүлсэн бөгөөд бусад эрхийг дараах байгууллагуудад шилжүүлсэн байна. Үүнд:

- НЗДТГ, УБЗАА, НЗХГ, НХОГ, ННТБГ, НОСК, ХБХГ, НГЗБА зэрэг харьяа газрууд 946,483.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 334 ТАХ буюу 39.0 хувь;
- ОНӨААТҮГ-ууд 52,135.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ буюу 2.0 хувь;
- Төслийн нэгжүүдэд 6,445.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ буюу 1.0 хувь;
- Өмнөх оноос шилжин хэрэгжих 790.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 145 ТАХ буюу 17.0 хувийг тус тус шилжүүлсэн байна.

График №1 НЗД-аас ХАА-ны эрхийг шилжүүлсэн байдал



ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1¹⁶-т заасны дагуу ТАХ-ний ХАА-г Төрийн Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

НЗД-аас НХААГ-т ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байдлыг авч үзвэл 36.7 хувь буюу 97 ТАХ-г 100 хүртэл хоногийн дотор шилжүүлж, 63.3 хувь буюу 168 ТАХ-г 100-аас дээш хоногийн дараа /2024.03.15-2024.12.03/ шилжүүлсэн нь нийслэлийн төсвийг удаа дараа тодотгосонтой холбоотой байна. Тухайлбал:

- НЗД-ын 2024 оны А/1288 захирамжаар НХААГ-т 5,385.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй /машин механизм/ 2 ТАХ-ний эрхийг шилжүүлсэн боловч техникийн тодорхойлолт шаардлага хангаагүй шалтгаанаар үнэлгээний хороо буцаахаар шийдвэрлэснээс хугацаа алдаж тайлант онд дуусаагүй;

¹⁶ 9.1.Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

- НЗД-ын 2024 оны А/1156 дугаар захирамжаар НХААГ-т 2,240.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй /дэд бүтэц/ Ус зайлуулах шугамын ажил (Сонгинохайрхан дүүрэг, 22 дугаар хороо) зураг төсөв боловсруулах, ажлын даалгавар батлуулах явцад цаг хугацаа алдсан, тендер сонгон шалгаруулалт зарласан хэдий ч шаардлага хангасан оролцогчгүй зэргээс шалтгаалж тухайн онд дуусаагүй;
- НЗД-ын 2024 оны А/1156 дугаар захирамжаар НХААГ-т 3,702.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаанбаатар театр” ОНӨТҮГ-ын барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр шалгаруулсан нь тухайн онд хэрэгжих боломжгүй болсон;
- НЗД-ын 2024 оны А/1203 дугаартай захирамжаар НХААГ-т 24,341.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын 6 ажлын ХАА зохион байгуулах эрхийг шилжүүлсэн боловч тухайн онд багтан 1 гүйцэтгэгч шалгарсан, 5 ТАХ-ний тендер сонгон шалгаруулалт зарласан ч шаардлага хангасан оролцогчгүйгээс тайлант онд хэрэгжээгүй байна.

ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан 5,425,938.4 сая төгрөгийн төсөвтэй 296 ТАХ-нээс аудитын түүвэрт 4,982,877.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 107 ТАХ буюу 37.4 хувийг хамруулахад дараах зөрчлүүд илэрсэн.

Хавсралт 8 Тухайлбал:

- “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийн 2 дугаар шугамын 2 зогсоол болон зарим тулгуур багануудын гадна тохижилт, зураг, төсөл, инженерийн дэд бүтцийн ажил, төсөвт өртөг 6,800.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан “Цагаан уран хийц” компанийн хүний нөөцийн болон ижил төстэй ажилд гүйцэтгэсэн талаарх шаардлагыг хангаагүй;
- Боловсролын салбарын барилгын их засварын багц-6, төсөвт өртөг 230.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан “Аббадон констракшн ХХК” ижил төстэй ажлын шаардлагыг хангаагүй;
- БГД-ийн 2 дугаар хороонд 26-34 дүгээр байр, 27 дугаар хорооны 1-9 дүгээр байрны ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажил 2 төсөл арга хэмжээ, 26-34 дүгээр байрны ажлын төсөвт өртөг 5,018.7 сая төгрөг, 1-9 дүгээр байрны ажлын төсөвт өртөг 14,990.6 сая төгрөг, гүйцэтгэгч Эс Энд эй трэйд ХХК хүний нөөцийн шаардлагыг хангаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Дүгнэлт: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй, өрсөлдөх боломжийг ханган зохион байгуулсан боловч шаардлагад нийцээгүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчил илэрч байна.

Б.2. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хяналт хэрэгжүүлж, хүлээн авсан уу?

Өмнөх оноос он дамжсан болон шинээр хэрэгжсэн нийт 2,097,432.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 788 ТАХ-д НХОГ ОНӨААТҮГ, НЗХГ, НЗДТГ, УБЗАА, ХБХГ, НГЗБА, НЭМГ, ННТБГ, УБ-Лифт ОНӨТҮГ зэрэг 20 байгууллага захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ. /Тайлбар: Нийслэлийн төсвийн 2024 онд шинээр хэрэгжсэн 431, өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 357, нийт 788 ТАХ/

Хүснэгт 9. Он дамжсан, тайлант онд хэрэгжсэн, хэрэгжээгүй ТАХ

№	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн	ТАХ-ний					
		Гэрээ байгуулагдсан		Үүнээс			
		Тоо	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан		Хэрэгжиж дуусаагүй	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
1	ЗХУТ	4	83,786.95	-	-	4	83,786.95
2	НГЗБА	14	2,149.74	10	1,794.94	4	354.80
3	НЗДТГ	7	23,537.44	4	16,138.44	3	7,399.00
4	НЗХГ	384	788,969.00	63	170,871.25	321	618,097.75
5	ННТБГ	2	84,424.48	1	61,625.40	1	22,799.08
6	НОБГ	1	100.00	1	100.00	-	-
7	НОСК ОНӨААТҮГ	1	4,000.00	1	4,000.00	-	-
8	НУБХАЗТБНТХН	4	159,405.90	-	-	4	159,405.90
9	НХБХГ	1	149.68	-	-	1	149.68
10	НХОГ	293	856,793.60	83	100,155.48	210	756,638.12
11	НЦХМТГ	6	10,391.18	2	4,568.89	4	5,822.28
12	НЭМГ	15	5,120.60	1	950.40	14	4,170.20
13	СХДЗД	16	41,270.40	6	7,925.48	10	33,344.92
14	УБ Лифт	2	2,148.41	1	998.40	1	1,150.00
15	УБЗАА	10	11,067.91	2	184.49	8	10,883.42
16	УБХГХХОДХТНэгж	11	4,648.13	11	4,648.13	-	-
17	УБХХХХБШТ-ийн нэгж	2	378.00	2	378.00	-	-
18	УСУГ	1	498.00	1	498.00	-	-
19	ХБХГ	7	16,252.72	6	16,052.72	1	200.00
20	ХБХСГ	7	2,340.10	4	1,991.43	3	348.67
НИЙТ		788	2,097,432.25	199	392,881.45	589	1,704,550.80

Дээрх ТАХ-нүүдээс 392,881.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 199 ТАХ буюу 25.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1,704,550.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 589 ТАХ буюу 74.7 хувь нь тайлант онд дуусаагүй, он дамжин хэрэгжихээр байна.

Дараах ТАХ-үүд төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжиж дууссан байна. Тухайлбал:

- БНД-ийн 1 дүгээр хороо, 50МВт/200МВтц-н хүчин чадал бүхий эрчим хүч хуримтлуурын станцын ажил, гүйцэтгэгч “Энвижн энерги” ХХК, гэрээний дүн 293,578.0 сая төгрөг.
 - Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтын 2.1.5¹⁷-д дэд бүтцийн салбарт, эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортлох зорилтын хүрээнд төвийн бүсийн нэгдсэн сүлжээтэй зэрэгцээ ажиллах 50 МВт хүчин чадалтай, 200 МВт.цагийн багтаамжтай эрчим хүч хуримтлуурын станц барьж байгуулах ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн;
 - Тус төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр эрчим хүчний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжсэн дотоодын найдвартай эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортлох зорилтод чиглэсэн байна.
- БГД-ийн 25, 28 дугаар хороодод “Хорооны цогцолбор барилга” худалдан авах ажил, гэрээний дүн 4,189.7 сая төгрөг, гүйцэтгэгч иргэн Н.Мөнхчимэг, НХОГ/2024-БА-4 дугаартай худалдан авах ажлын хэсгийн комиссын дүгнэлт гарч баталгаажсан байна.
 - Тус ТАХ хэрэгжсэнээр иргэд төрийн үйлчилгээг, хүртээмжтэй байдлаар хүндрэлгүй, түргэн шуурхай, нэг дороос авах орчин бүрдсэн байна.

¹⁷ Дэд бүтцийн салбарын үзүүлэлтэд чиглэсэн Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортлох

- СБД-т байрлах тусгай хэрэгцээт 29 дүгээр сургууль, дотуур байрны их засварын ажил, гэрээний дүн 4,800.0 сая төгрөг, “Гурван тахилгат оргил” ХХК тус ажлыг гүйцэтгэж 2024 оны 12 сард улсын комисс хүлээн авсан байна.
 - Олон жил болсон барилга байгууламжид, их засварын ажил хийснээр тусгай хэрэгцээт сурагчдыг ая тухтай сурч, амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Зураг 1. Хэрэгжиж дууссан ТАХ



Тайлбар: БНД, Эрчим хүч, хуримтлуурын станц



Тайлбар: БГД, 28 дугаар хорооны барилга

Хэрэгжиж буй төсөл арга хэмжээ:

- БЗД-ийн 43 хороо, СБД-ийн 1 хороонд байрлах “Сэлбэ сэргэлт төслийн Сэлбэ дунд голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн угсралт, Багц-1, гэрээний дүн 19,594,0 сая төгрөг, гүйцэтгэгч “Билгүүн Монгол Констракшн” ХХК, гэрээний хугацаа 2024-2026 он.
 - Баруун далангийн урд хэсгийн арматур угсралт хэв, хашмал хийцлэлийн ажил, зүүн хойд хэсгийн трассын дагуу бэлтгэл бетон цутгах ажил хийгдсэн, ажлын явц 60 хувьтай хэрэгжиж байна.

Өмнөх оноос дамжин хэрэгжсэн болон шинээр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдсан 2,097,432.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 788 ТАХ-ээс 684,192.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 110 ТАХ-г аудитын түүвэрт хамруулан шалгахад зураг төсөвт тусгагдсан ажлууд бүрэн хийгдээгүй, чанартай гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг хэтрүүлсэн, гэрээний тусгай нөхцөлийг зөрчсөн зэрэг зөрчлүүд илэрсэн. Тухайлбал:

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ төлөвлөсөнтэй холбоотой илэрсэн зөрчлүүд, тухайлбал:

- БЗД-ийн 12 дугаар хороо, 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, гэрээний дүн 9,485.8 сая төгрөг, гүйцэтгэгч “Жинсийн орой” ХХК, газрын асуудлыг бүрэн шийдвэрлээгүйгээс шалтгаалж ажлын явц удааширсан, 2024 онд магадлалын дүгнэлт баталгаажсанаар төсөвт өртөг 7,280.1 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- БЗД-ийн 15 дугаар хороо, 122 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, гэрээний дүн 2,994.4 сая төгрөг, гүйцэтгэгч “Жаргалант ургамал” ХХК, дулаан хангамжийн эх үүсвэр тодорхойгүй, зураг төсөвт магадлал хийгдэж төсөвт өртөг 2,188.2 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- БЗД-ийн 18 дугаар хороо, 129 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, гэрээний дүн 3,199.0 сая төгрөг, гүйцэтгэгч “Баярс констракшн” ХХК, ажлыг зураг төсөвгүй төлөвлөсөн, гүйцэтгэлийн явцад зураг төсөв боловсруулж магадлалын дүгнэлт баталгаажсанаар төсөвт өртөг 1,813.8 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- БЗД-ийн 19 дүгээр хороо, 240 ортой цэцэрлэгийн барилга, гэрээний дүн 6,464.4 сая төгрөг, гүйцэтгэгч “Ди Би Ти Би” ХХК, цахилгаан болон дулааны эх үүсвэрийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүйгээс ажил удааширсан;
- ХУД-ийн 8 дугаар хороо, 240 ортой цэцэрлэгийн барилга, гэрээний дүн 6,259.1 сая төгрөг, гүйцэтгэгч “Жинст цамхаг” ХХК, гадна дулааны шугамын трасс нь “Степе- Арена” ХХК-ны гадна ногоон байгууламжийг дайран гарахаар ажлын зурагт тусгагдсан ч тус газраас зөвшөөрөл олгоогүй шалтгаанаар удааширсан.

Зураг 2. Дулаан, цахилгааны асуудлаас шалтгаалж, хөрөнгө оруулалтын ажил удааширсан ТАХ



Тайлбар: ХУД, 8 дугаар хороо Цэцэрлэгийн барилга
240 ор "Жинст цамхаг" ХХК



Тайлбар: БЗД, 19 хороо Цэцэрлэгийн барилга
240 ор "Ди Би Ти Би" ХХК

Зураг 3. Цэвэр усны зөвшөөрөл олгогдоогүйгээс ажил удааширсан



Тайлбар: ХУД 16 хороо, 640 хүүхдийн сургууль, Гэрээний
дүн: 15,323.2 сая төгрөг.
Гүйцэтгэгч: "Билгүүн Монгол констракшн" ХХК



Тайлбар: ХУД, 16 хороо, Бага сургууль, цэцэрлэгийн
цогцолбор, Гэрээний дүн: 6,808.4 сая төгрөг.
Гүйцэтгэгч: "ЗМК Глобал ХХК"

ХУД-ын 16 дугаар хороонд Бага сургууль цэцэрлэгийн цогцолбор болон сургуулийн барилгыг 2022-2025 онд барьж дуусгасан боловч цэвэр усны асуудлыг шийдвэрлээгүйгээс улсын комисс хүлээн аваагүй, удаашралтай байна.

Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх явцад үүссэн хүндрэл бэрхшээл, тулгарсан асуудлын шалтгаан, үр дагаврыг тухай бүр судалж шийдвэрлээгүйгээс 2022 онд эхэлсэн дараах ТАХ зогсонги байдалтай байна. Үүнд:

- БЗД-ийн 11 дүгээр хороо, Бага тэнгэрийн ам-Туул гол дагуух амралт, зугаалгын цогцолборын тохижилт, гэрээний дүн 4,476.7 сая төгрөг, гүйцэтгэгч "Эйч ар ви констракшн" ХХК, төсөл арга хэмжээг гүйцэтгэх явцад тохижилтын ажил 2 удаа үерийн усанд автсан, гүйцэтгэгч засварыг дахин хийсэн ч улсын комисс ажиллаагүй;
- НД-ийн 7 дугаар хороо, Дүүргийн нутгийн захиргааны байр, гэрээний дүн 14,268.0 сая төгрөг, гүйцэтгэгч "Рино инженеринг" ХХК, "ДОСТ" ХХК-ийн түншлэл, анх төлөвлөгдсөн газар нь инженер геологийн дүгнэлтээр цэвдэг хөрстэйгөөс шалтгаалж ашиглагч байгууллагаас барилгын байршлыг 5 дугаар хороонд шилжүүлж, инженер геологийн дүгнэлтийг дахин гаргуулсан. Мөн тухайн газар нь цэвдэг хөрстэй, хөрсний ус илэрсэн тул геологийн дүгнэлт хийлгэхээр шийдвэрлэсэн боловч 2023, 2024 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүйгээс ажил нь зогссон байна.

Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс илэрсэн зөрчил, тухайлбал:

- 152 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (НД, 1 дүгээр хороо), гэрээний дүн 1,346.9 сая төгрөг, гүйцэтгэгч "Грэйт майнинг" ХХК, гэрээний хугацаа 2022-2024.08.31-нд дуусах, гүйцэтгэгчид нийт 924.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
 - Барилгын суурийн ажлыг хүйтний улиралд хийснээс шалтгаалж хөлдсөн, суурийг дахин хийсэн, ажил бүрэн дуусаагүй, цомцог гэрийн холбоос гал тогоо, бие засах хэсгийн барилгын дээврийн ажил, дотор өрлөг дуусаагүй, шавардлага дутуу хийгдсэн;
 - Цонх, цонхны тавцанг суулгаж дуусаагүй, гүйцэтгэгч шалтгаангүйгээр ажлаа орхиж явсан;

- 2024 онд нийт 699.7 сая төгрөг санхүүжихээс 279.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон; ажил хийгдээгүй тул үлдэгдэл санхүүжилт буцаан татагдсан;
- Захиалагч ажлын явцыг 74 хувиар хянаж, 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр гэрээ цуцлах мэдэгдэл гаргасан.
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Соёлын ордны барилга (БХД, 1 дүгээр хороо) гэрээний дүн 5,152.0 сая төгрөг, гүйцэтгэгч “Адамант” ХХК, гэрээний хугацаа 2020-2025 он, гүйцэтгэгчид нийт 1,939.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
 - 2024 онд ТАХ-ний явц 1-р давхрын өрлөг, 2,3 дугаар давхрын цутгалт, арматурын дотор өрлөг өрлөг хийгдэж дуусаагүй;
 - Тухайн онд 2,392.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 979.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Гүйцэтгэгч компанийн хүний нөөцийн чадавхаас шалтгаалж ажил хийгдээгүйн улмаас үлдэгдэл санхүүжилт татагдсан;
- Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Налайх дүүргийн ерөнхий боловсролын 109 дүгээр сургуулийн гадна талбайд Хөл бөмбөгийн талбай байгуулах, гэрээний дүн 118.7 сая төгрөг, гүйцэтгэгч “Номун заяа” ХХК, гэрээний хугацаа 2020-2022 он.
 - Хөл бөмбөгийн зүлэг, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдээгүй, гэрээний хугацааг 2023.07.01-ний өдөр хүртэл сунгахаар шийдвэрлэсэн ч гүйцэтгэгч ажлаа хаяж явсан;
- Гэр хорооллын тохижилтын ажил БНД, 5 дугаар хороо, гэрээний дүн 214,9 сая төгрөг. гүйцэтгэгч “Хөхбугат” ХХК, гэрээний хугацаа 2022-2024 он, гүйцэтгэгчид нийт 185.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
 - Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажлыг хийж гүйцэтгэсэн ч хүлээн авах улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж төсөл арга хэмжээ зогсонги байдалд орсон байна.

Зураг 4. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй ТАХ



Тайлбар: БНД, Гэр хорооллын тохижилтын ажил



Тайлбар: НД, Хөл бөмбөгийн талбай байгуулах.



Тайлбар: НД, Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө



Тайлбар: БХД, Соёлын ордон

Захиалагчийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, зураг төсөвт тусгагдсан ажлыг бүрэн хийгээгүй, чанартай гүйцэтгээгүй дараах зөрчлүүд байна, тухайлбал:

- БГД-ийн 18 дугаар хороо, Түшиц хана засварлах ажил, гэрээний дүн 957.4 сая төгрөг, гүйцэтгэгч “Өсөн үржих констракшн” ХХК, хөгжлийн бэрхшээлтэй хүний налуу замыг стандарт, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байхад улсын комисс хүлээн авсан;
- БГД-ийн 73 болон Оюуны ундраа сургуулийн гал тогооны их засварын ажил, гэрээний дүн 115.0 сая төгрөг, гүйцэтгэгч “Төсөв төсөл” ХХК, үе шатны ажил дуусаагүй байхад гүйцэтгэгчээс “ажил дууссан, комисс ажиллуулж өгнө үү” гэсэн агуулга бүхий хүргүүлсэн албан бичгийг үндэслэн захиалагч ажлын явцтай танилцаагүй, хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний хугацааг сунгасан;
- БГД-ийн 21 дүгээр хороо, Цэцэрлэгийн барилга, гэрээний дүн 3,376.8 сая төгрөг, гүйцэтгэгч “Тотал-Идеал” ХХК, барилга угсралтын ажлын явцад бүрдүүлсэн баримт бичигт барилгын

суурийн нүхийг ажлын зургийн дагуу ухсаныг шалгасан, зоорины нүхийг хөрсний гадаргуугийн уснаас хамгаалсан, барилгын хэсгийн зоорь, суурийн нүхийг хэдэн метрийн гүнтэй ухсан, ухагдсан газрын хөрсний дүгнэлт, ухаж дууссан шуудуунд суурь хийхэд саад байсан зэргийг ил, далд актаар баталгаажуулаагүй нь Барилгын тухай хуулийн 37.1.19¹⁸, 40.1.2¹⁹-д заасантай нийцээгүй;

Зураг 5. БГД, 18 дугаар хороо Түшиц хана засварлах ажил



Тайлбар: Хөгжлийн бэрхшээлтэй хүний явах замын стандарт хангагдаагүй байдал

- Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажил, гэрээний дүн 2,996,9 сая төгрөг, гүйцэтгэгч “Хасу Эрчим ХХК”, дэд станцын ил хуваарилах байгууламжийн гадна тоноглолыг суурилуулсан газарт хөрсний суулт ихтэй, металл хийцлэлд зэврэлт үүссэн;
- Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил, гэрээний дүн 16,289,5 сая төгрөг, гүйцэтгэгч “Вилвест” ХХК, Би Эс Би энерги ХХК, Виртуал софт ХХК-ийн түншлэл”, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг трассын дагуу байрлуулахдаа суурийн хэсгийн газар шорооны ажлыг бүрэн хийгээгүй, металл хийцлэлд зэврэлт үүссэн;
- Дээрх 110 кВт-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, захиалагчийн техникийн хяналт, ашиглалтад хүлээн авах ажлуудыг зохион байгуулахдаа “Эрчим хүчний барилга байгууламжийг барих” ажлын журмын 1.1²⁰-д заасан ерөнхий зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, барилга угсралтыг гүйцэтгэхдээ журмын 4.1²¹, 4.2²²-т зааснаар “*өөрчлөлт орсон зураг, баримт бичиг, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баримтжуулсан байдал*”, Эрчим хүчний нэгдсэн сүлжээний Скада системд тоноглолыг холбоход үүссэн асуудлыг шийдвэрлэсэн талаарх албажуулсан баримт бичгийн бүрдэлт хангалтгүй, техникийн комиссын бүрэлдэхүүнд нэн шаардлагатай, эрчим хүчний нэгдсэн системийн горим тооцоололд шийдвэр гаргах байгууллагын инженер техникийн бүрэлдэхүүнийг оролцуулаагүй, комисс ажилласан протокол, хурлын тэмдэглэлгүй байна.
- Сонгинохайрхан дүүрэг, 30 дугаар хороо, 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, хэрэгжих хугацаа 2022-2025 онд төсөвт өртөг 14,514.0 сая төгрөг, гүйцэтгэгч Хөшиг-Уул ХХК, Барилга угсралтын ажлын гүйцэтгэл №4-т барилгын А, В, Г блокийн гадна хананд 494.83м3 дүүргэлт хийсэн ажлыг хянан баталгаажуулсан ч гадна ханын дүүргэлтийн өрлөгөөс спорт заалны буюу Г корпусын 3 талд хийгдэх 54м3 гулдмай өрлөг хийгдээгүй байхад гүйцэтгэлээр тооцсон.

Аудитын явцад стандартын шаардлага хангаагүй дараах төсөл арга хэмжээнд гүйцэтгэгчид хугацаатай үүрэг чиглэл өгч залруулсан.

- Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Цэцэрлэгийн барилга худалдаж авах ажил, гэрээний дүн 5,500.0 сая төгрөг, гүйцэтгэгч “Алтан спорт клуб” ХХК, 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр цэцэрлэгийн барилга хүлээн авах ажлын хэсэг ажиллаж 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн НХОГ/2024-БА-109 дугаартай ажлын хэсгийн дүгнэлт баталгаажсан ба цэцэрлэгийн барилгын зарим хэсэгт цэцэрлэгийн стандарт мөрдөөгүйгээс цахилгааны утас, залгуур хүүхдийн гар хүрэх буюу доор байрласан, шат халтиргаанаас хамгаалсан наалтгүй, агааржуулалт хангалтгүй байсныг аудитын явцад үүрэг даалгавар өгч засуулж ажилласан.

¹⁸37.1.19. Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах;


¹⁹40.1.2. Барилгын ажил гүйцэтгэгч барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

²⁰“Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгийн эх үүсвэр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эрчим хүчний барилга байгууламж /цаашид “барилга байгууламж” гэж/ барих /барьж байгуулах, шинэчлэл хийх, сэргээн засварлах, өргөтгөл/ ажлыг зохион байгуулах хүрээнд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна”.

²¹ 4.1. Гүйцэтгэгч нь дор дурдсан үүрэгтэй байна:

²² 4.2. Захиалагч нь дор дурдсан үүрэгтэй байна:

Зураг 6. ХУД, 23 хороо цэцэрлэгийн барилга худалдан авах ТАХ



Тайлбар: цэцэрлэгийн барилгын зарим хэсгийн шатанд хүүхэд халтирч унахаас хамгаалсан резин байхгүй, цахилгаан тогийн залгуур хананы доор хэсэгт байсныг стандартын дагуу байрлуулсан

Цаашид гүйцэтгэгчийн болон захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй албан хаагчдын үүрэг хариуцлагыг сайжруулах, эвдэрсэн болон дутуу, чанартай гүйцэтгээгүй ажлыг дахин хийлгэх, эргэн мэдэгдэх, хугацаа хэтэрсэн тохиолдолд алданги тооцох, хугацаа алдалгүй нэмэлт гэрээг сунгах, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нарт хуулийн дагуу хариуцлага тооцох, аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: Зураг төсөвт тусгагдсан ажлуудыг бүрэн хийгээгүй, чанартай гүйцэтгээгүй, гэрээний хугацааг сунгахдаа 10-60 хоногийн хугацаа алдаж нэмэлт гэрээг байгуулсан, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ШИЙДВЭРЛЭЖ, ХӨРӨНГӨ БҮРТГЭЛД ТУСГАСАН УУ?

В.1. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”-аар заасан.


Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих 200,311.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 45,421.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 24 ТАХ-ний санхүүжих дүнг 100.0-7.222.4 сая төгрөг буюу 6.0-46.0 хувиар дутуу тусгасан байна.

Хавсралт 9

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6²³-д “тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх”-аар заасан ч 2024 онд шинээр хэрэгжүүлэх 228,683.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний санхүүжих дүнг 622.4-143,522.3 сая төгрөг, нийт 168,826.1 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. **Хавсралт 10**

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгаж батлахдаа тухайн онд санхүүжих дүнг холбогдох зардлын тооцооллыг хийгээгүй, тойм дүнгээр төсөвт тусгаж баталж байгаагаас ТАХ нь магадлалын дүгнэлтийн төсөвт өртгөөр өөрчлөгдсөн байна. Тухайлбал:

Дүрслэл 4. Төсөвт өртөг, санхүүжих дүнг тойм дүнгээр төсөвт тусгасан ТАХ



Төвлөрсөн 3 хогийн цэгийн пүү, программ хангамж (Улаанбаатар хот) ТАХ-г 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, санхүүжих дүнтэйгээр баталсан ч 2024 оны 05 дугаар сарын 713/2024, 728/2024, 745/2024 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтүүдээр 1,578.8 сая төгрөг болж буурсан байна.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтийг төлөвлөхдөө хэрэгжих хугацаатай уялдуулаагүй байна.

²³ 29.3.6.тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

В.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 2,508,019.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 597 ТАХ-нд 2024 онд 1,916,478.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 485 ТАХ-нд 1,124,973.2 сая төгрөг олгосон нь нийт санхүүжих дүнгийн 44.8 хувийг нь эзэлж байна.

Үүнээс нийслэлийн төсвийн эх үүсвэрээс санхүүжигдэх 2,044,437.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 431 ТАХ-нд 886,027.7 сая төгрөг буюу 43.3 хувь, нийслэлийн замын сангийн 166,727.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 79 ТАХ-нд 81,602.9 сая төгрөг буюу 48.9 хувь, их засварын 14,300.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 15 ТАХ-нд 9,581.3 сая төгрөг буюу 67.0 хувь, үнэт цаасны 282,554.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 72 ТАХ-нд 146,861.4 сая төгрөг буюу 52.0 хувийн санхүүжилтийг тус тус олгожээ.

Хүснэгт 10. Нийслэлийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар олгосон санхүүжилт (сая.төг)

№	Хөрөнгийн эх үүсвэр	2024 24/32 дугаар тогтоолоор					Гэрээний дүн		Олгосон		
		Багц ТАХ	ТАХ тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих		ТАХ тоо	Дүн	ТАХ тоо	Дүн	Хувь
					Дүн	Хувь					
1	Нийслэлийн төсөв	347	528	7,381,178.5	1,672,618.5	22.7	431	2,044,437.3	334	886,027.7	43.3
2	Нийслэлийн замын сан	24	285	90,737.7	77,860.2	85.8	79	166,727.4	74	81,602.9	48.9
3	Их засвар	4	19	16,000.0	16,000.0	100.0	15	14,300.6	13	9,581.3	67.0
4	Үнэт цаас	2	92	325,498.9	150,000.0	46.1	72	282,554.3	64	146,861.4	52.0
НИЙТ		377	924	7,813,415.1	1,916,478.7	24.5	597	2,508,019.4	485	1,124,073.2	44.8

Нийт олгосон санхүүжилтээс 8,649.4 сая төгрөг буюу 1.0 хувийг нь техник хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал эзэлж байна.

Хэрэгжиж дууссан ТАХ-ний 10,103.6 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

Гэрээний үүргээ зөрчсөн 8 гүйцэтгэгчид гэрээний хугацаа хэтрүүлсэн 21.2 сая төгрөгийн алдангийг захиалагч байгууллагаас тооцсон байна. Үүнд:

Хүснэгт 11. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй

№	ТАХ-ний нэр	Эхлэх он	Дуусах он	Захиалагчийн хяналт	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчийн нэр	Алданги
1	Биеийн тамир, спорт хорооны барилгын фасад засварын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 34 дүгээр хороо)	2024	2024	СХД	697.0	Тэрэсо ХХК	15.5
2	12 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо)	2022	2024	НХОГ	1,190.3	Бумбод ХХК	0.6
3	Сагсан бөмбөгийн талбай болон тохижилтын ажил (БЗД, 8 дугаар хороо)	2022	2024	НХОГ	40.0	Рино инженеринг ХХК	1.9
4	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо/	2022	2024	НХОГ	6,259.1	Жинст цамхаг ХХК	0.2
5	Барилгын засвар (Баянгол дүүрэг, 6, 18 дугаар хороо, Оюуны ундраа, Эрдмийн өргөө цогцолбор сургууль)	2023	2024	НХОГ	55.0	Төрөлхмөрөн ХХК	0.2
6	Барилга, сантехникийн засвар (Баянгол дүүрэг, 18 дугаар хороо, 11 дүгээр цэцэрлэг)	2023	2024	НХОГ	56.0	АОММ ХХК	0.2
7	Барилгын засвар (Хан-Уул дүүрэг, 9 дүгээр хороо, 134 дүгээр цэцэрлэг)	2023	2024	НХОГ	50.0	Төрөлхмөрөн ХХК	0.4
8	БАГЦ-7: Боловсролын салбарын барилгын их засвар (Сүхбаатар дүүрэг, 6 дугаар сургууль, 160 дугаар цэцэрлэг, Баянгол дүүрэг, 77 дугаар цэцэрлэг, Чингэлтэй дүүрэг, 56 дугаар цэцэрлэг)	2024	2024	НХОГ	286.8	Грэйт майнинг ХХК	2.4
НИЙТ					8,634.2		21.2

Санхүүжилт олгосон дансны хуулга, гэрээний хэрэгжилттэй холбоотой баримтуудыг /гэрээ дүгнэсэн протокол, ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн актууд/ шалгахад гэрээний хугацаа дууссан ч гүйцэтгэгч гэрээт ажлаа бүрэн хийгээгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй зэрэг шалтгаанаар гэрээний хугацааг 120-883 хоногоор хэтэрсэн зөрчил илэрсэнд 347.0 сая төгрөгийн дүн бүхий алданги тооцоогүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг НХОГ ОНӨААТҮГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт 12. Гэрээний алданги тооцоогүй төсөл арга хэмжээ

(сая.төг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн	Алдангийн хувь	Алданги тооцоогүй хоног	Алдангийн дүн
1	Гэр хорооллын тохижилтын ажил (БНД, 5 дугаар хороо)	Хөх бугат ХХК	215.0	0.5 хоног	564	84.5
2	152 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Налайх дүүрэг, 1 дүгээр хороо)	Грейт майнинг ХХК	1,347.0	0.5 хоног	120	253.6
3	Налайх дүүргийн ерөнхий боловсролын 109 дүгээр сургуулийн гадна талбайд Хөл бөмбөгийн талбай байгуулах	Номун заяа ХХК	118.7	0.5 хоног	883	8.9
НИЙТ			1,680.7			347.0

Аудитын явцад дараах алдааг залруулж ажилласан. Үүнд:

- НЗДТГ болон “Эс энд Эй Трейд” ХХК-ийн хооронд 2024.09.20-ны өдөр НХААГ/20240101560 дугаартай, 13,861.9 сая төгрөгийн үнийн дүнтэй “БГД, 27 дугаар хороо, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай давхрын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажил”-ын гэрээг байгуулсан байна. Гэвч:
 - Гэрээ байгуулагдсанаас хойших хугацаанд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй;
 - Тендер шалгаруулалтын баримт бичигт “Урьдчилгаа төлбөр олгохгүй” байхаар тусгасан ч “Монре” даатгал ХХК-иас 2024.09.30-ний өдөр ирүүлсэн 10254/00016/09/24LI дугаартай урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн Нийслэлийн ЗДТГ болон НХОГ ОНӨААТҮГ-аас хяналтын чиг үүргээ дутуу хэрэгжүүлж “Эс энд Эй Трейд” ХХК-нд 4,158.0 сая төгрөгийг урьдчилгаа төлбөр олгосон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.1²⁴, 43.3²⁵ дахь заалтыг зөрчсөн учир аудитын явцад урьдчилгаа төлбөрт олгосон 4,158.0 сая төгрөгийн санхүүжилтийг нийслэлийн төсвийн орлогын дансанд буцаан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 78,059.0 төгрөгийн гэрээний дүнтэй 13 ТАХ-нд олгосон санхүүжилтийг санхүү бүртгэлийн программд бүртгэхдээ 3,769.9 сая төгрөгөөр дутуу бүртгэж ЗГ-ын 2023 оны 278 дугаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.9²⁶, 2.2.12²⁷ дахь заалтыг зөрчсөн байсныг аудитын явцад залруулж бүртгүүлсэн.

²⁴ 43.1.Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө.

²⁵ 43.3.Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.

²⁶ 2.2.9.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн хяналтыг хэрэгжүүлэх, хянан баталгаажуулах;

²⁷ 2.2.12.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн бүрэн, үнэн зөв бүрдүүлэх;

Дүгнэлт: Он дамжих болон шинээр хэрэгжих 377 багц ТАХ-нд тайлант онд 1,916,478.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 1,124,073.2 сая төгрөг буюу 58.6 хувийг олгосон боловч урьдчилаа төлбөр олгохдоо холбогдох хууль, гэрээг зөрчсөн, алданги тооцоогүй, санхүү бүртгэлийг бүрэн хөтлөөгүй зэрэг зөрчил илэрч байна.

В.3. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, өмчийн бүртгэлд тусгасан уу?

НИТХ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.1²⁸-т заасны дагуу хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжсэн хуулийн этгээдийн санхүүгийн тайланд бүртгэдэг байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжиж дууссан 392,881.4 сая төгрөгийн өртөг бүхий 199 ТАХ бүртгэх байсан нь барилга байгууламж, авто зам, дэд бүтцийн чиглэлийн 119 ТАХ, техник, тоног төхөөрөмжийн 17 ТАХ, их засвар, тохижилтын ажлын 41 ТАХ, зураг төсөв зөвлөх үйлчилгээний 22 ТАХ тус тус эзэлж байна.

Үүнээс барилга байгууламжийн ангилалд хамаарах сургууль, цэцэрлэгийн барилга худалдан авсан 22,323.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ-г НИТХ-ын шийдвэрээр холбогдох байгууллагын санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

Хүснэгт 13.Хөрөнгө бүртгэлд тусгасан ТАХ

(сая.төг)

№	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	Бүртгэсэн шийдвэр	Бүртгэсэн огноо	Хөрөнгийн дүн	Бүртгэлд тусгасан байгууллагын нэр
1	Орон сууцны 1 давхар, 75 ор /Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо/	НИТХ-ын 2024 оны 32 тоот тогтоол, НЗД-ын 2024 оны А/417-р захирамж	2024.03.25 2024.04.10	1,292.0	БЗД-ийн 52-р цэцэрлэг
2	Орон сууцны 1 давхар, 75 ор /Баянзүрх дүүрэг, 43 дугаар хороо/	НИТХ-ын 2024 оны 32 тоот тогтоол, НЗД-ын 2024 оны А/417-р захирамж	2024.03.25 2024.04.10	1,820.0	БЗД-ийн 321-р цэцэрлэг
3	Орон сууцны 1 давхар, 50 ор /Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/	НИТХ-ын 2024 оны 32 тоот тогтоол, НЗД-ын 2024 оны А/417-р захирамж	2024.03.25 2024.04.10	1,100.0	БЗД-ийн 321-р цэцэрлэг
4	Бие даасан барилга, 50 ор (Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо)	НИТХ-ын 2024 оны 112 тоот тогтоол, НЗД-ын 2024 оны А/1291-р захирамж	2024.09.19 2024.11.04	1,600.0	БЗД-ийн 267-р цэцэрлэг
5	Бие даасан барилга, 50 ор (Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо)	НИТХ-ын 2024 оны 112 тоот тогтоол, НЗД-ын 2024 оны А/1291-р захирамж	2024.09.19 2024.11.04	1,600.0	БЗД-ийн 319-р цэцэрлэг
6	Цэцэрлэгийн барилга худалдан авах,280 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо/	НИТХ-н 32 тогтоол, НЗД-н А/417 захирамж	2024.03.25, 2024.04.10	4,373.9	СХД-ийн 330 дугаар цэцэрлэг
7	Орон сууцны 1 давхар,75 ор /Хан-Уул дүүрэг 4-р хороо/	НИТХ-н 53 тогтоол, НЗД-н А/609 захирамж	2024.04.29, 2024.05.28	572.7	Хан-Уул дүүргийн 145-р цэцэрлэг
8	Цэцэрлэгийн барилга 100 ор /Хан-Уул дүүрэг 3-р хороо/	НИТХ-н 53 тогтоол, НЗД-н А/609 захирамж	2024.04.29, 2024.05.28	1,676.0	Хан-Уул дүүргийн 322-р цэцэрлэг
9	Орон сууцны 1 давхар, 150 ор /Хан-Уул дүүрэг 11-р хороо/	НИТХ-н 53 тогтоол, НЗД-н А/609 захирамж	2024.04.29, 2024.05.28	2,862.4	Хан-Уул дүүргийн 324-р цэцэрлэг
10	Орон сууцны 1 давхар, 100 ор /Хан-Уул дүүрэг 17-р хороо/	НИТХ-н 53 тогтоол, НЗД-н А/609 захирамж	2024.04.29, 2024.05.28	3,400.0	Хан-Уул дүүргийн 325-р цэцэрлэг
11	Монгол өв соёл уламжлал, ёс заншлын өргөөний барилгын ажил /Сонгинохайрхан дүүргийн 33-р хороо, Тахилтын задгай 122 дугаар сургуулийн хажуу талд/	НИТХ-н 112 тогтоол, НЗД-н А/1291 захирамж	2024.09.19 2024.11.04	1,040.7	Сонгинохайрхан дүүргийн 188-р цэцэрлэг

²⁸ Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын зээл хөтөлбөр, буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг тухайн төсөл хэрэгжүүлсэн хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэнэ.

12	Монгол өв соёл уламжлал, ёс заншлын өргөөний барилгын ажил /Сонгинохайрхан дүүргийн 33-р хороо, Давхарын буудал, 10 дугаар гудамж/	НИТХ-н 112 тогтоол, НЗД-н А/1291 захирамж	2024.09.19 2024.11.04	985.4	Сонгинохайрхан дүүргийн 271-р цэцэрлэг
НИЙТ				22,323.1	

Бусад ТАХ-ны ангиллын хувьд баримт бичгийн бүрдүүлбэр хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах зэрэг ажлууд үргэлжилж 2025 онд бүртгэгдэхээр төлөвлөсөн нь төсөвт тодотголд орж зарим ажил цаг хугацааны хувьд оройтож хэрэгжсэн, явц удааширсан зэргээс шалтгаалж байна.

Дүгнэлт: Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төсөвт баталсан нь хөрөнгө оруулалтын төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нь нэмэгдэх зэргээр төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд нь нөлөөлж байна.
2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон зарим барилга байгууламж, техник тоног төхөөрөмж нь стандартын болон чанарын шаардлагыг бүрэн хангаагүй байна.
3. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 2,097,432.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 788 ТАХ-ээс 199 ТАХ буюу 25.3 хувь нь хэрэгжиж дууссан, 589 ТАХ буюу 74.7 хувь нь дуусаагүй, он дамжин хэрэгжиж байна.
4. Нийслэлийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан УБ хотын нийгэм, эдийн засагт нөлөөлөх, улс орны бодлогын хэмжээний томоохон ТАХ-г үр дүнтэй хэрэгжүүлснээр иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжрах, автозамын түгжрэл буурах, сургууль цэцэрлэгийн хүртээмж нэмэгдэх зэрэг боломж бүрдэхээр байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Х.Нямбаатар/-д:

1. Төсвийн тухай хуульд тогтоомжид заасан төсөвлөлтийн шаардлага бүрэн хангасан ТАХ-г хөрөнгө оруулалтын төсөвт төлөвлөж батлуулах;
2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа болон гүйцэтгэлийн шатанд гарсан зөрчлийг арилгаж, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т

1. Гэрээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Наадмчдын зам 1200, Ариатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.05.15 № 03/3135
тантай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Нийслэл дэх Төрийн Аудитын газраас
"Нийслэлийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлд холбогдох байгууллагуудаас
егөх саналыг нэгтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Цаашид аудитын хүрээнд гарсан дүгнэлтүүдийн
дагуу тодорхой арга хэмжээ авч ажиллан, өгсөн
зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АМГАЛАН

1725112595



НИЙСЛЭЛИЙН "ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТУГ

Наадмчдын зам 1201, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100, Утас: (976-11) 31 16 32
Цахим шуудан: Nhog@invest.ub.gov.mn
Цахим хуудас: www.invest.ub.gov.mn


2025.05.15 № 01/1938
тантай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу
хавсралтаар тайлбар хүргүүлж байна.

- 1 дүгээр хавсралт: тайлбар, 2 хуудастай.
- 2 дугаар хавсралт: файл, 25 хуудастай.
- 3 дугаар хавсралт: тайлбар, 6 хуудастай.



